Аудитын код: САГ-2018/9/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

“Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК
Захирал: Ч.Энхтуяа
Утас: 99110581 Цахим хаяг: enkhtuya@hlbm.mn

Аудит менежер:М.Нурболат
Утас: 99027275 Цахим хаяг: nurbolat@hlbm.mn

Ахлах аудитор:Ц.Таванчулуу
Утас: 99177464 Цахим хаяг: tavanchuluu.ts@hlbm.mn

Аудиторын туслах: Ч.Батгэрэл
Утас: 99779100Цахим хаяг: batgerel.ch@hlbm.mn

Аудиторын туслах: Э.Уужимсан, Б.Цацрал, М.Нямсүрэн, Б.Оюунбилэг, У.Сүхдарь

Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо “Гурван гал” төв 6 давхар, 607 тоот
Цахим хаяг: www.hlbm.mn
И-мэйл: info@hlbm.mn

Улаанбаатар хот

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Агуулга

1 Аудитын гэрчилгээ 1
2 Аудитын тайлан 1
2.1 Оршил 1
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага 1
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин 2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн 4
2.5 Дотоод хяналт 5
2.6 Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга 5
2.7 Шилэн дансны мэдээлэл 6
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар 7
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл 7
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал 7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд 9
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл 10
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 10
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: 10
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл 10
3 Менежментийн захидал 11
3.1 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгийн талаар 12
3.2 Биет бус хөрөнгө 13
3.3 Авлагын талаар 13
3.4 Үндсэн хөрөнгийн талаар 14
3.5 Нэмэгдсэн өртгийн албан татварын талаар 14
3.6 Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн талаар 15
4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний биелэлтийн судалгаа 16
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан 16
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийнтайлан 18
4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 19
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан 20
4.5 Аудит хийгдсэн зорилтод түвшний биелэлтийн судалгаа 21

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1 Аудитын гэрчилгээ

“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын батлсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Эрдэнэс Монгол” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ

БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

"Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд авлага, брлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, НӨАТ, борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансдын материаллаг бус зөрчилд өгсөн санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх 6-н зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу програм хангамж ашиглан үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 13-наас 2018 оны 03 дугаар сарын 13-ны хооронд хийхээр төлөвлөн “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн Ахлах аудитор Ц.Таванчулуу ахлагчтай аудитын баг хэрэгжүүлэв.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 13-нд “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийгмийн даатгал болон Татварын багц хуулиуд болон холбогдох Улсын Их Хурлын болон Засгийн Газрын тогтоолуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус компанийг анх Засгийн газрын 2006 оны 266 дугаар тогтоолыг үндэслэн, Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-ны 2007 оны 52 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, компанийн дүрмийг баталжээ. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа компанийн дурмийг Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн мөрдөж буй хууль тогтоомж, эрх зүйн актуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тус компанийн цахим хуудаснаас авч болно. http://www.erdenesmongol.mn/index.php?view=article&type=item&val=197

“Эрдэнэс Монгол” ХХК нь Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд (САХБАМО) болон стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийн орд (САХБЭБО)-ыг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдөр үүсгэн байгуулагджээ.

“Эрдэнэс Монгол” ХХК нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд болон тэдгээртэй хамаарал бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төрд ногдох хувь, төрийн мэдлийн хувьцааг эзэмшиж, тэдгээрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь өргөтгөж ашигт ажиллагааг сайжруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө босгох, нэмүү өртөг бий болгох боловсруулах үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, компаниудын үйл ажиллагаанд Засгийн газрын бодлогыг уялдуулах зэргээр нэгдсэн стратеги, удирдлагаар хангахад анхаарч ажилладаг.

Одоогийн байдлаар компани нь “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 86%, “Эрдэнэс Оюу толгой” ХХК-ийн 100%, “Багануур” ХК-ийн 75%, “Шивээ Овоо” ХК-ийн 90%, “Мон-Атом” ХХК-ийн 100%, “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК-ийн 50%, “Эрдэнэс Метан” ХХК-ийн 100%, “Эрдэнэс Ассет менежмент” ХХК-ийн 100%, “Эрдэнэс Ашид” ХХК-ийн 34%, “Эрдэнэс Стийл” ХХК-ийн 50%-ийн хувьцааг шууд эзэмшиж байна. Мөн “Оюу толгой” ХХК-ийн Монголын талын 34%-ийг өөрийн охин компаниар дамжуулан эзэмшиж, Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн автозамын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг “Гашуун сухайт авто зам” ХХК-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр байгуулан ажиллуулж байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус компани цаашид байгалийн нөөцийг үр ашигтай удирдах замаар улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд жинтэй хувь нэмэр оруулахуйц үндэсний тэргүүлэгч компани төдийгүй үйл ажиллагаандаа олон улсын стандартыг нэвтрүүлсэн, компанийн өрсөлдөх чадвар, үнэ цэнийг нэмэгдүүлсэн, олон улсын зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн компани болох бизнесийн зорилгоо бүрэн дүүрэн биелүүлэхээр зорьж байна.

Монгол Улсын байгалийн нөөцийг үр ашигтай ашиглаж, уул уурхай, дэд бүтэц, эрчим хүчний салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигч иргэдэд бодит үр ашгийг хүртээх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах үндэсний хөрөнгө оруулалтын компани болох нь “Эрдэнэс Монгол” компанийн эрхэм зорилго юм.

Азийн Хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагын чадавхийг сайжруулах төслийн хүрээнд байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж, сайжруулах зорилготой холбогдох стандарт, журмыг судлах, тохиромжтой тооцооллын арга хэрэгслийг тодорхойлох, шинэчлэх ажлуудыг хийж байна.

Компанийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгажээ.

Төрийн төлөөллийг хэрэгжүүлэх талаар:

- САХБАМО-ын төрийн эзэмшлийн хувьцаа эзэмших эрх эдлэх
- Төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого
- САХБАМО-ыг ашиглах урьдчилгааны орлогыг төвлөрүүлэх
- Төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг нэмэгдүүлэх

Стратегийн ордын ашиглалтын талаар:

- Ашигт малтмын геологийн судалгааны хайгуулын ажил гүйцэтгэх
- САХБАМО-ын нөөц, хил хязгаарыг тогтоох аргачлал, зарчмыг боловсруулан эрх бүхий эрх бүхий байгууллагаар батлуулах
- Ордыг дангаараа болон бусад этгээдтэй хамтран ашиглах
- Ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйлдвэр байгуулах
- Дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Нөөцийн хуваарилалт, тээвэр, агуулах, гаалийн хяналтын бүсийн үйлчилгээ
- Ашигт малтмалыг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх

Тусгай зөвшөөрөл, эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар:

- САХБАМО-ын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших, шилжүүлэх, барьцаалах
- САХБАМО-ын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, тооллогыг зохион байгуулах
- Эд хөрөнгө, тоног төхөөрөмж болон оюуны өмчийн эрхийг эзэмших, ашиглах, түрээслэх, худалдах

01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Санхүүжилтийн эх үүсвэр олох, хуваарилах талаар:

- САХБАМО-ын ашиглалтын чиглэлээр IPO, PP хийх замаар хөрөнгө оруулалтыг татах
- Эрх бүхий байгууллагын шийдвэрээр өрийн бичиг /бонд/ гаргах, хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдэд зээл олгох
- Ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн оролцоотой компаниудын төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, стратегийн хөрөнгө оруулагчийг татан оролцуулах

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх талаар:

- Маркетингийн бодлого, дунд, урт хугацааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах
- ТЭЗҮ, нөөцийн үнэлгээ, хөрөнгө, санхүүгийн төлөвлөлт хийх
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх
- САХБАМО-ын мэдээллийг дотоод, гадаадад сурталчлах, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс тус компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5-3/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2011 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд тууштай мөрдөж ажилласан байна. Уг Бодлогын баримт бичигт байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалж шинээр бий болсон ажил гүйлгээнүүдийг бүртгэх горим болон СТОУС, холбогдох хууль эрх зүйн өөрчлөлтийг тусгаагүй байсан зэрэг хүчин зүйлсээс улбаалан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 27-ны өдрийн 45 дугаар тогтоолоор баталж 2018 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөж ажиллаж байна.

Мөн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Винница” програмаар боловсруулан нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Дотоодын хяналтын нэгжийн 2017 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, хуваарийг баталж ажилласан байна.

ТУЗ-ийн дэргэдэх Дотоод хяналтын нэгж /ДХН/ нь эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын үйл явцын үр нөлөөтэй байдлыг системтэй, эмх цэгцтэй арга, хандлагаар үнэлэх, сайжруулах замаар компанийг зорилгоо биелүүлэхэд нь дэмжлэг болох үндсэн зорилготой компанийн хэмжээнд хяналтын ажлыг зохион байгуулж ажилласан байна.

ТУЗ-ийн даргын өгсөн удирдамжийн дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоол, шийдвэрийн биелэлт, санхүүгийн анхан шатны баримтын бүртгэл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт зэрэгт 2017 оны 7 дугаар сард хэсэгчилсэн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн байна. Хяналтаар дээрх ажлууд “хангалттай” хэрэгжиж байна гэж дүгнэжээ.

Мөн ТУЗ-ийн шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврыг ДХН-тэй урьдчилсан байдлаар санал солилцож хамтран ажиллах зөвлөгөө өгч, хэрэгжиж байна. Хяналтын ажлын тайланг ТУЗ-ийн гишүүдэд танилцуулж 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2 дугаар тэмдэглэлээр шалгалтын тайланд дурдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шийдвэр гарган хяналт тавьж ажиллаж байна.

2.6 Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Эрдэнэс Монгол” ХХК нь 2017 онд төлөвлөгдсөн нийт орлого нь 65,560.8 сая төгрөг, гүйцэтгэлээр орлого нь 64,245.9 сая төгрөг буюу 98.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт орлого нь замын хураамжийн орлого – 56,757.8 сая төгрөг, менежментийн төлбөрийн орлого – 5,515.9 сая төгрөг, талбай ашигласны төлбөрийн орлого – 224.4 сая төгрөг, бусад тендерийн материалын орлого – 35.8 сая төгрөг, бусад хүүний орлого – 1,711.9 сая төгрөгийн орлогуудаас бүрдэж байна.

“Эрдэнэс Монгол” ХХК нь Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн тусгай зориулалтын хатуу хучилттай авто замын ашиглалтыг сайжруулах, шороон замын тээвэрлэлтийг зогсоож байгаль экологийг хамгаалах, цаашид гүйцэтгэх үйл ажиллагааны талаар зам ашиглагч, тээвэрлэгчидтэй хамтран ажиллах зорилгоор Зам, тээврийн сайдын 2015 оны 3 дугаар сарын 31-ний 86 дугаар тушаалаар БНХАУ-д нийлүүлэх нүүрсний тээврийн чиглэлийг тогтоосон байна.

Нүүрс тээвэрлэлтийн тарифыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2015 оны а/36 тоот тушаалаар 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 1 тн тутамд 1.0 ам.доллар байхаар тогтоож байсан. 2016 онд гүйцэтгэх захирлын

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

тушаалаар 1 тн нүүрс тээвэрлэх тарифыг 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 2,000 төгрөгөөр, 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 3,200 төгрөг байхаар тогтоож байжээ.

Тайлант хугацааны 2017 оны замын хураамжийн орлогыг өмнөх 2016 оны орлоготой харьцуулахад 28,276.0 сая төгрөг буюу 99%-иар өссөн шалтгаан нь замын хураамжаа 3200 төгрөг болгож нэмэгдүүлсэнтэй холбоотой ба 2017 онд нүүрсний экспорт нэмэгдэж "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төсөвлөсөн нүүрсний хэмжээнээс 3.9 сая тонн илүү тээвэрлэгдсэн байна.

2017 онд төсөвлөгдсөн нийт үйл ажиллагааны зардал 40,941.2 сая төгрөгөөс гүйцэтгэлээр 34,619.8 сая төгрөг буюу төсөвлөгдсөн зардлын 84.6 хувийг зарцуулсан байна. Үйл ажиллагааны зардал нь Гашуун сухайтын авто замын зардал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зардлуудаас бүрдэж байна. Гашуун сухайтын авто замын зардалд зээлийг хүүгийн зардал – 10,338.0 сая төгрөг, зам засвар, үйл ажиллагааны зардалд - 16,205.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үйл ажиллагааны зардалд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа төслийн зардлууд тодорхой хувийг эзэлж байна. Үүнд:

1. “Эрдэнэс Монгол компаний засаглал, удирдлагын чадавхийг бэхжүүлэх” төсөл /49409-001/.

Азийн Хөгжлийн банкны 35.0 сая ам.долларын зээлээр хэрэгжиж байгаа. Гэрээний дагуу 2016 онд 5,246.2 мянган ам.долларын, 2017 онд 1,661.5 мянган ам.долларын зээлийг тус тус хүлээн авч, зээлийн хүүгийн өглөгт 2016 онд 57.6 мянган ам.долларыг, 2017 онд 151.9 мянган ам.долларыг тус тус хуримтлуулж тооцсон байна. Төслийн нэгжийн зардалд 2017 онд 4,394.6 сая төгрөг зарцуулжээ.

2. Үндэсний брэндийн төсөл.

Үндэсний брэндийн зөвлөлийн ажлын албаны урсгал зардалд 2017 онд 344.6 сая төгрөг, гэрээний дагуу гадаадын байгууллагад төлөх төлбөрт 1,209.6 сая төгрөгийг “Эрдэнэс Монгол” ХХК-иас санхүүжүүлсан байна. Нийт төсөв нь 1,728.5 сая төгрөгөөр батлагдсан байна.

3. Эрчим хүчний экспортын “Шивээ Энержи” цогцолбор төсөл.

Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 422 дугаар тогтоолоор Шивээ Овоогийн нүүрсний ордыг түшиглэн эрчим хүчний цогцолбор байгуулан төсөл хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангаж, зохион байгуулах үүрэг бүхий төслийн нэгжийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэд байгуулах зөвшөөрөл олгож, төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг батлагдсан орон тоо, төсөвт багтаан санхүүжүүлж, шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг үүрэг болгосны дагуу 2017 онд 118.6 сая төгрөгийн зардал гарсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

“Эрдэнэс Монгол” ХХК нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсаар “Шилэн дансны тухай” хуулийг хэрэгжүүлж байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 6 дугаар зүйлийн 6.8.1-д заасны дагуу доорх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлдэг байна. Үүнд:

1. Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл
2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд заасан мэдээлэл
3. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл
4. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 37 тендер зарлахаас 23 тендер /нийт 12,823.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй/ амжилттай болж гэрээ байгууллагдаж, дүгнэгдэж, мэдээллээ шилэн дансанд байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан албан тушаалтнууд мэдээллийг иргэн олон нийтэд хүргэх үүргээ биелүүлж ажиллаж байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 144 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 144 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Стандарт, дүрэм, журмыг дагаж мөрдөөгүй,татвартай холбогдох тооцооллыг дутуу хийсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга тодруулга, эрх үүргийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Урьдчилж төлсөн зардлын талаар

Урьдчилж төлсөн зардал дансны 2017.12.31-ны байдлаар буй Засгийн Газрын өрийн баталгааны эцсийн үлдэгдэл 9,301.5 сая төгрөгөөс 8,599.5 сая төгрөг нь ангиллын хувьд буруу бүртгэгдсэн.

Шийдвэрлэсэн нь: Бусад эргэлтийн бус хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэх талаар зөвлөмж өгсөн.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Азийн хөгжлийн банкнаас 2016 онд “Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

хүрээнд 35,000.0 мянган ам.долларын зээл авах гэрээ байгуулж, 2016 онд 5,246.2 мянган ам.долларыг, 2017 онд 1,661.5 мянган ам.долларыг тус тус хүлээн авч зээлийн хүүнд 2016 онд 57.6 мянган ам.долларыг, 2017 онд 151.9 мянган ам.долларыг зээлийн хүүгийн өглөгт тооцсон байна.

Зээлийг 2019 оны 9 дүгээр сараас эхлэн 12 жилийн хугацаанд зээлийн хүүгийн хамт төлнө. Зээлдэгч нь зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн гүйцэтгэлд Монгол Улсыг төлөөлж Сангийн сайд баталгаа гаргасан байна. Баталгааны эрх үүргийн хүрээнд Сангийн яам нь “Эрдэнэс Монгол” ХХК-тай “Засгийн газрын өрийн баталгааны авлага барагдуулах гэрээ”-г 2016 оны 6 дугаар сарын 3-нд байгуулсан. Засгийн газар өрийн баталгаа гаргах болсонтой холбогдуулж, Засгийн газрын өрийн баталгааны санд баталгаа гаргуулагч Эрдэнэс Монгол ХХК нь 5,250.0 мянган ам.доллар буюу 10,530.0 сая төгрөгийн шимтгэл байршуулж, тайлант хугацаанд 526.5 сая төгрөгийг шимтгэлийн зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 38 дугаар захирамжаар Дэлхийд Монгол Улсын үнэлэмж, байр суурь, монгол хүний үнэ цэнийг нэмэгдүүлэн таниулах бодлогыг зохицуулах үүрэг бүхий “Үндэсний брэнд”-ийн зөвлөлийг байгуулж, Үндэсний брэндийн зөвлөлийн ажлын албыг өөрийн бүтэц дотроо байгуулж, үйл ажиллагааны зардлыг төсвөөсөө санхүүжүүлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасан байна. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Төслийн нэгж байгуулж, нэгжийн үйл ажиллагааны журмыг, 2017 оны 13 дугаар тогтоолоор төслийн нэгжийн зардлыг, Гүйцэтгэх захирлын 2017 оны А/56 дугаар тушаалаар төслийн нэгжийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан байна. Үндэсний брэндийн зөвлөлийн ажлын албаны урсгал зардалд 2017 онд 344.5 сая төгрөг, гэрээний дагуу гадаадын байгууллагад төлөх төлбөрт 1.209,6 сая төгрөгийг “Эрдэнэс Монгол” ХХК-наас санхүүжүүлсэн байна. Нийт төсөв нь 1,728.5 сая төгрөгөөр батлагдсан байна.

3. Засгийн газрын 2015 оны 449 дүгээр тогтоолын дагуу Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн 239 км хүнд даацын, тусгай зориулалтын авто зам, Гашуунсухайт боомтын дэд бүтцийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсэнтэй холбоотойгоор Хөгжлийн банкнаас авсан 170,595.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг зохицуулсан 2/800 тоот гэрээг 2015 оны 12 дугаар сарын 31-нд Хөгжлийн банк, Сангийн яамны төлөөлөлтэй баталгаажуулсан байна. Гэрээнд үндсэн зээлийг 2019, 2020 онд 2 үе шаттайгаар төлөх, хуримтлагдсан хүүг 2017 онд багтаан төлөх, үндсэн хүүг хуваарийн дагуу төлөхөөр заасан байна. 2017 онд хуримтлагдсан хүүгийн өглөг 21,151.4 сая төгрөгийг төлж 2,294.3 сая төгрөгийн хүүгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

4. Гашуун сухайтын авто замыг дагаж ирсэн боомтыг хил, гаалийн төрийн захиргааны байгууллага ашиглаж байгаа бөгөөд дээрх хөрөнгийн ашиглалт нь авто замын ашиглалттай хамааралгүй болон тус компанийн үйл ажиллагаанд зориулагдаагүй учраас холбогдох газарт шилжүүлнэ гэж үзээд санхүүгийн тайлангийн эргэлтийн хөрөнгийн хэсэгт Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгөөр бүртгэж, толилуулж байна. Одоогоор дээрх биет хөрөнгөнд элэгдэл хорогдол, үнэ цэнийн бууралтыг тооцоогүй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын баг нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн хүрээнд аудит хийсэн бөгөөд тус компанийн хөрөнгө оруулсан охин болон хараат компанийн тайланг хамруулаагүй болно.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд ... “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын биелэлтийг бүрэн хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч тайлагнахыг даалгасан байна.

Уг тогтоолын товч агуулга нь “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн зарласан, гаргасан хувьцааг дүрэмд тусгаж өөрчлөлт оруулах, Засгийн Газарт нэрлэсэн үнээр худалдах хүсэлт гаргасан иргэд, аж ахуйн нэгжийн хувьцааг худалдан авах арга хэмжээг зохион байгуулах, “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн хувьцааны бүртгэлийг эцэслэх, төрийн эзэмшлийн хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэр дээр шилжүүлэх, толгой болон охин компанийн санхүүгийн тайланд холбогдох бичилтийг тусгах, “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн ордын үнэлгээ хийх, Монгол Улсын хөгжлийн банкнаас ЭТТ, ЭМГЛ-д тус тус олгосон зээлийг хувьцаанд хөрвүүлэх зэрэг байна.

”Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн төрийн эзэмшлийн 65.2 хувь буюу 9,780.7 сая ширхэг хувьцааг нэрлэсэн үнэ 933 төгрөгөөр 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа бүртгэн баталгаажуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосны дагуу 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр санхүүгийн тайландаа залруулга оруулж эзэмшигчийн өмчийг 9,125,184.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тусгажээ.

Энэ асуудалтай холбоотойгоор аудит хийх цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалгаалж, нарийн судалгаа хийгээгүй бөгөөд дараагийн аудитаар авч үзэх асуудалд оруулж байна.

“Эрдэнэс Монгол” ХХК дээр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг цаашид анхаарч, дараагийн аудитаар нарийвчлан үзвэл зохино. Үүнд:

1. 2016 онд Азийн хөгжлийн банкнаас “Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх төсөл”
2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 38 дугаар захирамжаар дэлхийд Монгол Улсын үнэлэмж, байр суурь, монгол хүний үнэ цэнийг нэмэгдүүлэн таниулах бодлогыг зохицуулах үүрэг бүхий “Үндэсний брэнд”-ийн зөвлөлийг байгуулж, Үндэсний брэндийн зөвлөлийн ажлын албыг өөрийн бүтэц дотроо байгуулж, үйл ажиллагааны зардлыг төсвөөсөө санхүүжүүлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасан байна.
3. Эрчим хүчний экспортын “Шивээ Энержи” цогцолбор төсөл. Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 422 дугаар тогтоолоор Шивээ Овоогийн нүүрсний ордыг түшиглэн эрчим хүчний цогцолбор байгуулан төсөл хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангаж, зохион байгуулах үүрэг бүхий төслийн нэгжийг “Эрдэнэс Монгол” ХХК-ний дэргэд байгуулах зөвшөөрөл олгож, төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан санхүүжүүлж, шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг үүрэг болгосон.

01 ЗӨВ ТӨЛӨГ САНАЛ ДАЛГАЛЗАХ

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 178,139.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 169,539.6 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж, 8,599.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж, дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагад анхааруулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Эрдэнэс Монгол” ХХК–ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Од бүртгэл аудит” ХХК гүйцэтгэж, аудитаар өгсөн 5 зөвлөмжийн зарим зөвлөмжийг биелүүлээгүй байна. Үүнд:

1. Тайлагналын талаар өгсөн зөвлөмж Асуудал-1-д заасан:

Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, өр төлбөрийн ханшийн зөрүүг тооцсон дүнгээс хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр (116.1 сая төгрөг) үүсгээгүйд өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй байна.

НББОУС 12 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө, Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүү зохицуулах” журмын дагуу хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг үүсгэх байсан.

2. Хөрөнгө оруулалтын талаар өгсөн зөвлөмж Асуудал-2-т заасан:

“Мон-Атом” ХХК-д оруулсан Хөрөнгө оруулалтыг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэх аргыг тодорхой тодруулах зөвлөмж өгснийг биелүүлээгүй байна.

Нийт өгсөн зөвлөмжийн биелэлт 75 хувьтай биелүүлж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байна гэж үзлээ.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитаар материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн шатанд нийт хөрөнгийн 1.5 хувь буюу 3’495.0 сая төгрөгөөр тогтоосон.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бидний үзэж байгаагаар, Эрдэнэс Монгол ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага нь аудит бүрийн төгсгөлд аудит болон бусад ажлаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой өгсөн бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

2013 оны Засгийн газрын 299 дүгээр тогтоолоор "Энержи ресурс" ХХК-ийн 11,589,359,171.46 /НӨАТ-гүй дүн/ төгрөгийн өртөг бүхий Гашуунсухайт боомтын дэд бүтцийг төрийн өмчид худалдан авахаар шийдвэрлэж, уг хөрөнгийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн мэдэлд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Компани нь уг хөрөнгийг хөгжлийн банкны зээлээр авсан бөгөөд хуваарийн дагуу зээлийн хүүг төлж байгаа болно. Уг хөрөнгийг Эрдэнэс Монгол ХХК санхүүгийн тайландаа Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөд тусгасан. Компаниас томилогдсон ажилчдын 2017 оны 12-р сарын 08-ны өдрийн уг хөрөнгүүдэд хийсэн тооллогын акттай танилцахад зарим хөрөнгө эвдэрхий, ажиллагаагүй мөн дутсан зэрэг зөрчлүүд ажиглагдлаа.
Мөн тайлант хугацаанд Гашуунсухайт боомтын гэрэлтүүлгийн цамхаг ажлын зураг төсөл, 8 айлын байрны зураг төсөл, байрны засвар зэрэгт зарцуулсан 66,591,828.18 төгрөгийг /НӨАТ-гүй дүн/ уг ангилалд нэмж бүртгэсэн.
Монгол улсын хилийн тухай хуулийн хүрээнд компани нь уг дэд бүтцийг хариуцсан яам, байгууллагуудад шилжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дугаар тушаалаар батласан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Нягтлан бодох бүртгэлийн дансны ангилаллын жагсаалт”-тай нийцэхгүй байгаа болно.

ҮАГ-ын зөвлөмж

Гашуунсухайт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор барьсан дэд бүтцийн өмчлөл, бүртгэлтэй холбоотой асуудлыг Сангийн яамд шилжүүлэх ажлыг яаралтай зохион байгуулах, Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн өмчийн эд хөрөнгийг холбогдох журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу илэрхийлснээр шийдвэр гаргагчдын шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

3.2 Биет бус хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №2
ҮАГ-ын ажиглалт Таван толгой- Гашуун сухайт чиглэлийн 157'847'184'614.57 төгрөгний өртөгтэй 239 км авто замыг эзэмшиж байгаа боловч өмчлөх эрх байхгүй гэсэн шалтгаанаар элэгдэл байгуулдаггүй байна. Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дугаар тушаалаар батласан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Нягтлан бодох бүртгэлийн дансны ангилаллын жагсаалт”-тай нийцэхгүй байгаа болно.	**ҮАГ-ын зөвлөмж** Холбогдох хууль тогтоомжын дагуу уг тусгай зориулалтын авто замын өмчлөх эрхийг олж авах, замын ашиглалтын хугацааг тодорхойлж элэгдэл байгуулаж бүртгэх. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
Эрсдэлүүд Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө дутагдах, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах,	**Төсвийн захирагчийн хариу** Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.3 Авлагын талаар	Тэргүүлэх ач холбогдол №3
ҮАГ-ын ажиглалт Эрдэнэс Монгол ХХК нь 2017 онд авлагын насжилтийн шинжилгээ тооцоогүй, найдваргүй авлагын нөөц байгуулаагүй. Холбогдох хууль тогтоомж, журам, заавар зөрчсөн байх	**ҮАГ-ын зөвлөмж** 2018 оноос хэрэгжиж эхлэх НББББББ-ийн дагуу найдваргүй авлагын сан байгуулж бүртгэлд тусгах, санхүүгийн тайланд авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр үнэлэх. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6дугаар сарын 20-ныдотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
Эрсдэлүүд Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу илэрхийлснээр шийдвэр гаргагчдын шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй.	**Төсвийн захирагчийн хариу** Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

3.4 Үндсэн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Тус компанийн үндсэн хөрөнгийн санхүүгийн тайлангийн зорилгоорх ашиглалтын хугацаа нь татварын сууриарх ашиглалтын хугацаанаас ялгаатай байна. Санхүүгийн тайлангийн зорилгор байгуулсан элэгдлийн зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардлаар тооцож аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд тусгасан. зорилгоор тусдаа элэгдэл тооцоогүй, татварын эрсдэл үүсч болзошгүй.
Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам”-ын дагуу хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй.

ҮАГ-ын зөвлөмж

НББОУС-12, Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам”-уудын дагуу хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрч бүртгэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх,толилуулга тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаагаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, Татвар ногдуулах орлогыг буруу тайлагнах, татварын эрсдэл үүсэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.5 Нэмэгдсэн өртгийн албан татварын талаар	Тэргүүлэх ач холбогдол №5

ҮАГ-ын ажиглалт

Эрдэнэс Монгол ХХК нь Эрнст Янг Аудит ХХК-тай Эрдэнэс Монгол ХХК болон охин компаниудын 2016 оны жилийн эцсийн тусдаа болон нэгтгэсэн санхүүгийн тайланд аудитын үйлчилгээний гэрээ байгуулсан. Төлбөрийг 100 хувь Эрдэнэс Монгол ХХК төлсөн бөгөөд охин компаниудын аудитын үйлчилгээний хөлсийг охин компаниудаас авах авлагаар /НӨАТ-гүй дүнгээр/ бүртгэсэн боловч нийт төлбөрийн НӨАТ-ыг зөвхөн өөрийн байгууллага дээр бүртгэж НӨАТ-т хасалт хийсэн.

ҮАГ-ын зөвлөмж

Харилцагч байгууллагаар ажил үйлчилгээний НӨАТ-ыг охин компаниудруу бичүүлж, охин компаниудаас НӨАТ тэй дүнгээр авлага үүсгэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу илэрхийлснээр шийдвэр гаргагчдын шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй.
Холбогдох хууль тогтоомж, журам, заавар зөрчсөн байх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

3.6 БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТГИЙН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №6

ҮАГ-ын ажиглалт

Автозамын шалган нэвтрүүлэх цэгт уншуулсан картаарх төлбөрөөс суутгасан банкны шимтгэл болох 13,500,545.0 төгрөгийн бүтээгдэхүүний өртөг дансанд бүртгэгдсэн.

Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дугаар тушаалаар батласан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Нягтлан бодох бүртгэлийн дансны ангилаллын жагсаалт”-тай нийцэхгүй байгаа болно.

ҮАГ-ын зөвлөмж

Банкны шимтгэлийн данс буюу үйл ажиллагааны зардалд тусгах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТИЙН СУДАЛГАА

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,146,141,635.63	11,871,985,311.00
Дансны авлага	4,057,270,329.55	3,710,715,421.60
Татвар, НДШ-ийн авлага	109,900,597.89	387,662,778.04
Бусад авлага	21,300,119,958.36	25,120,167,224.88
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	37,709,175.94	31,241,809.52
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10,413,112,816.37	1,710,259,306.49
Бусад эргэлтийн хөрөнгө	-	
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	11,589,359,171.46	11,655,950,999.64
Эргэлтийн хөрөнгийн дүн	**56,653,613,685.20**	**54,487,982,851.17**
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,581,937,170.87	2,361,074,770.02
Биет бус хөрөнгө	157,097,473,789.88	157,150,747,655.71
Урт хугацаат хөрөнгө оруулалт	751,000,000.00	9,128,695,451,467.00
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	46,788,491.67	51,155,535.95
Бусад эргэлтийн бус хөрөнгө	5,171,603,687.06	15,356,418,864.83
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**164,648,803,139.48**	**9,303,614,848,293.51**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**221,302,416,824.68**	**9,358,102,831,144.68**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Дансны өглөг	191,990,010.12	1,293,272,588.26
Цалингийн өглөг	57,553.26	172,108,952.00
Татварын өр	538,928,233.79	281,521,552.60
НДШ-ийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	-	-
Хүүний өглөг	13,622,744,926.25	2,294,205,401.84

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Урьдчилж орсон орлого	60,000.00	20,555,426.25
Бусад богино хугацаат өр төлбөр	457,471,364.98	237,431,742.86
Богино хугацаат өр төлбөрийн дүн	**14,811,252,088.40**	**4,299,095,663.81**
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	183,753,316,158.41	186,938,320,406.59
Бусад урт хугацаат өр төлбөр	71,417,743,738.81	67,195,150,944.29
Урт хугацаат өр төлбөрийн дүн	**255,171,059,897.22**	**254,133,471,350.88**
Өр төлбөрийн нийт дүн	**269,982,311,985.62**	**258,432,567,014.69**
Эздийн өмч		
Өмч: - төрийн	100,000,000.00	100,000,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Эздийн өмчийн бусад хэсэг	-	9,128,184,251,467.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(48,779,895,160.94)	(28,613,987,337.01)
Эздийн өмчийн дүн	**(48,679,895,160.94)**	**9,099,670,264,129.99**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**221,302,416,824.68**	**9,358,102,831,144.68**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийнтайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого (цэвэр)	33,780,689,091.79	62,533,964,803.43
Борлуулалтын өртөг	8,856,674,613.30	16,205,308,470.59
Нийт ашиг (алдагдал)	24,924,014,478.49	46,328,656,332.84
Түрээсийн орлого		
Хүүний орлого	633,680,090.70	1,711,950,887.01
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	12,666,714,384.00	10,837,383,332.06
Санхүүгийн зардал	11,379,833,914.94	11,484,303,105.22
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,162,804,257.81)	321,718,516.07
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(76,282,928.03)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)	(146,667,151.17)	(193,484,968.48)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	201,674,861.27	25,770,871,402.13
Орлогын татварын зардал	150,161,597.63	5,722,340,769.10
Татварын дараах ашиг (алдагдал)	51,513,263.64	20,048,530,633.03
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	51,513,263.64	20,048,530,633.03
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн		

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	385,947,248.97		(49,164,916,773.55)	(48,678,969,524.58)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				333,508,348.97	333,508,348.97
Залруулсан үлдэгдэл		385,947,248.97			385,947,248.97
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал				51,513,263.64	51,513,263.64
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	100,000,000.00	-		- -48,779,895,160.94	- -48,679,895,160.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				117,377,190.90	117,377,190.90
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал				20,048,530,633.03	20,048,530,633.03
Өмчид гарсан өөрчлөлт			9,128,184,251,467.00		9,128,184,251,467.00
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	100,000,000.00		9,128,184,251,467.00	-28,613,987,337.01	9,099,670,264,129.99

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Мөнгөн орлогын дүн	**32,786,440,371.79**	**63,033,732,729.02**
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	29,478,706,722.79	62,805,190,518.47
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	9,106,140.00
Буцаан авсан албан татвар	3,200,000,000.00	-
Бусад мөнгөн орлого	107,733,649.00	219,436,070.55
Мөнгөн зарлагын дүн	**35,596,634,334.90**	**62,312,073,853.09**
Ажиллагчдад төлсөн	2,590,650,647.86	4,605,102,497.37
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	498,095,962.72	932,779,002.83
Бараа материал худалдан авахад төлсөн	122,449,720.00	171,060,044.70
Ашиглалтын зардалд төлсөн	4,604,509.00	-
Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	88,808,285.00	96,279,158.00
Хүүний төлбөрт төлсөн	8,793,492,209.22	21,160,596,942.90
Татварын байгууллагад төлсөн	439,027,557.90	11,243,274,263.88
Бусад мөнгөн зарлага	23,059,505,443.20	24,102,981,943.41
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(2,810,193,963.11)**	**721,658,875.93**
Мөнгөн орлогын дүн	**476,253,835.52**	**2,246,976,322.10**
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	315,058,154.80	1,435,588,976.15
Хүлээн авсан хүүний орлого	161,195,680.72	811,387,345.95
Мөнгөн зарлагын дүн	**181,441,237.70**	**2,128,166,463.89**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	147,095,697.70	1,963,532,734.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	34,345,540.00	164,633,729.89
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**294,812,597.82**	**118,809,858.21**
Мөнгөн орлогын дүн	**13,876,268,027.51**	**3,137,638,043.51**
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	13,767,445,058.69	3,142,072,279.99
Бусад	108,822,968.82	(4,434,236.48)
Мөнгөн зарлагын дүн	**2,380,000,000.00**	**1,252,263,102.28**
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,380,000,000.00	1,252,263,102.28
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**11,496,268,027.51**	**1,885,374,941.23**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**8,980,886,662.22**	**2,725,843,675.37**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	165,254,973.41	9,146,141,635.63
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,146,141,635.63	11,871,985,311.00

ТӨГИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4.5 АУДИТ ХИЙГДСЭН ЗОРИЛТОД ТҮВШНИЙ БИЕЛЭЛТИЙН СУДАЛГАА

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/сая.төг/

	Үзүүлэлт	2017 оны		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	*2*	*3*	*4*	*5=4-3*
НИЙТ ОРЛОГО		**65,560.84**	**64,245.92**	**(1,314.93)**
	Замын хураамжийн орлого	59,602.69	56,757.80	(2,844.89)
	Менежментийн төлбөр	5,754.15	5,515.91	(238.25)
	Шивээ-Овоо талбай ашигласны төлбөр	204.00	224.40	20.40
	Бусад тендерийн материалын орлого	-	35.86	35.86
	Бусад хүүний орлого	-	1,711.95	1,711.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		**40,941.19**	**38,720.48**	**(2,292.94)**
	ГАШУУН СУХАЙТЫН АВТО ЗАМЫН ЗАРДАЛ	**30,088.26**	**26,543.39**	(3,544.87)
	Зээлийн хүүгийн зардал	10,338.09	10,338.09	0.00
	Зам засвар, үйл ажиллагааны зардал	19,750.17	16,205.31	(3,544.87)
	УРСГАЛ ЗАРДАЛ	**9,408.47**	**7,854.29**	**(1,626.41)**
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,627.20	2,448.45	(178.75)
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	283.79	274.66	(9.14)
	ТУЗ-ийн зардал	133.20	136.63	3.43
	ТУЗ-ийн дотоод хяналтын нэгж	106.56	113.30	6.74
	Оффис түрээс	718.80	714.16	(4.64)
	Засвар үйлчилгээ	24.00	20.51	(3.49)
	Харуул хамгаалалтын зардал	32.40	29.45	(2.95)
	Бичиг хэргийн зардал	56.78	50.10	(6.67)
	Хангамжийн материал	58.41	54.64	(3.77)
	Хурал зөвлөгөөн, уулзалтын зардал	331.70	295.05	(36.65)
	Мэдээлэл зар сурталчилгаа	1,958.00	1,784.44	(173.56)
	Гадаад томилолт	486.22	424.69	(61.53)
	Дотоод томилолт	96.60	85.70	(10.90)
	Гэрээт ажил	300.00	336.13	36.13
	Автын сэлбэг, засвар үйлчилгээ	89.10	42.37	(46.73)
	Шатахуун, шатах тослох материал	45.60	32.94	(12.66)
	Авто машины даатгалын зардал	26.80	18.10	(8.71)
	Сургалтын зардал	200.80	199.95	(0.85)
	Авлигын тухай сурталчилан таниулах зардал	3.00	-	(3.00)
	Шуудан харилцаа холбоо	54.10	52.65	(1.45)
	Ном, хэвлэл захиалга	11.60	10.45	(1.15)
	Тайлан үйлчилгээний зардал	184.76	148.76	(36.00)
	Нийгмийн арга хэмжээний зардал	237.30	193.48	(43.82)
	Элэгдлийн зардал	207.41	283.83	76.43
	Татвар төлбөр хураамж	3.14	3.51	0.37
	Шимтгэл хураамжийн зардал	31.20	28.10	(3.10)
	Хариуцлагын даатгал	100.00	-	(100.00)
	Эрсдлийн сангийн зардал	1,000.00	-	(1,000.00)
	Хүүгийн зардал	-	72.23	72.23
НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ		**1,444.47**	**4,322.80**	**2,878.33**
	АХБ-ны төслийн дотоод санхүүжилтийн зардал	1,444.47	4,322.80	2,878.33
	Бусад /гадаад валютын ханшийн зөрүүний олз /	-	321.71	321.71
	Бусад/ хөрөнгө данснаас хассаны гарз/	-	76.28	
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ АЛДАГДАЛ		**24,619.65**	**25,770.86**	**978.01**
	Орлогын албан татвар	5,704.95	5,722.34	17.39
ЦЭВЭР АШИГ АЛДАГДАЛ		**18,914.70**	**20,048.52**	**960.62**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ